

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.МИНДЖИНХҮҮ

2026 оны 12 сарын 12 өдөр

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХЖ-ИЙН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур	Хугацаа	Хариуцах эзэн
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулах	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас, б/сошиал сүлгууд, в/дотоод сүлжээ, г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандлагын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	Жилдээ	ЭБАТ Мэдээллийн Ил тод байдлыг хариуцсан ЭБАТ
		1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа соён гэгээрүүлэх арга хэмжээг Дотоодын цэргийн 05 дугаар ангитай хамтран зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	ЭБАТ Бүтээмж, сурталг хариуцсан мэргэжилтэн
		1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 1-110 дугаарыг оруулан сурталчлах;	-АТГ-ын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчлан ажигласан байх. -Тайланд 1-110 дугаарыг сурталчилсан баримт бүрийн нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	ЭБАТ
		1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	-Авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн контент бүтээлгэж олон нийтэд түгээж ажигласан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	Жилдээ	ЭБАТ

		1.5 Шүтэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	- компанийн албан ёсны вэйб сайт, болон бусад мэдээллийн сувгуудаар ажилтан албан хаагчдад шүтэл үлээхийг дэмжих, шүтэл үлээгчийг хамгаалах талаар сурталчилан таниулах богино хэмжээний геел, зурагт хуудас зохиомжлон оруулах, -Ур дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	жилдээ	ЭБАТ
		2.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	-Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаанд дахь иргэний нийгмийн оролцоо нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулсан байх;	Жилдээ	Мэдээллийн Ил тод байдлыг хариуцсан ЭБАТ
		2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн баталгаажсан санхүүгийн , гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг олон нийтэд ил тод байх нөхцлийг бүрдүүлэх	- Компанийн санхүүгийн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг компанийн албан ёсны вэйб сайт, шилэн дансны сайтуудад хуулийн дагуу оруулах ил тод байдлыг бүрэн хангах	Жилдээ	ЭБАТ СБХ
		2.3 Компанийн үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; Гомдол мэдээлэлд хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлэсэн байх	Жилдээ	ЭБАТ
		2.4 Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин хөлс, урамшуулал, тэтгэмж дэмжлэг ил тод байх тогтолцоог бүрдүүлэх	- Улирал бүр компанийн дүрэмд заагдсан эрх бүхий албан тушаалтнуудын мэдээллийг хуулийн хүрээнд компанийн албан ёсны сайтад байршуулах	Улирал бүр	Мэдээллийн Ил тод байдлыг хариуцсан ЭБАТ
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх				

3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах;	-Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулсан байх;	Жилдээ	ЭБАТ Мэдээллийн Ил тод байдлыг хариуцсан ЭБАТ
		3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчдын дунд авлигаас ангид байхад чиглэсэн нөлөөллийн үр дүнтэй ажил зохион байгуулсан байх;	Жилдээ	ЭБАТ
		3.3. Эрчим хүчний сайдаас баталсан захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах;	-Байгууллагын алба хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдоогүй байх; -Дүн шинжилгээ хийсэн байх	Жилдээ	ЭБАТ
		3.4. Эрчим хүч салбарын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;	- Эрчилтэй захиргааны хэм хэмжээний актуудыг хүчингүй болгох, хуулиар эрх олгосон боловч зохих акт гаргаагүй бол боловсруулах, батлах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх; - Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	Жилдээ	ЭБАТ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЗУХ-ИЙН ДАРГА, ЭБАТ



Г.МӨНГӨНЦЭЦЭГ